

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



ШИЖИР ХИЙЦ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б. БАТЭРДЭНЭ



РЕМЕНЬ БОЛОН ТУСЛАХ СЭЛБЭГ, МАТЕРИАЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 36/2022

2022 оны 04-р сарын 12 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш. Баянмөнх нөгөө талаас Шижир хийц ХХК-ийг төлөөлж захирал Б. Батэрдэнэ /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Ремень болон туслах сэлбэг, материал” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ 38,160,000 /Гучин найман сая нэг зуун жаран мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Капитрон банкны 3052011778 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3 Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Түлш дамжуулах цехийн дарга Д.Түвшинзаяа хариуцан ажиллана. Утас- 99026048.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Шижир хийц ХХК-ийн захирал Б.Батэрдэнэ хариуцан ажиллана. Утас- 99859709.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед эвдэрч гэмтэхээс хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согогийг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.


Найм. Гэрээг цуцлах үндэслэл


- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.


Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
АЖ АХУЙ, ХАНГАМЖ
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
Б. УРТНАСАН
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 


ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН ДАРГА
Д.ТҮВШИНЗАЯА
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.ГАНТУЛГА
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ШИЖИР ХИЙЦ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
Б.БАТЭРДЭНЭ
Гарын үсэг: 



Хаяг: Орхон аймаг баян өндөр сум Их залуу баг 12а-4
Утас: 99859709
РД: 4398874

**РЕМЕНЬ БОЛОН ТУСЛАХ СЭЛБЭГ, МАТЕРИАЛ
БАРААНЫ ЖАГСААЛТ**

№	Бараа материалын нэрс	Техникийн тодорхойлолт марк тип	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /НӨАТ/-эй
1	Анхдагч /А/бутлуурын хүч дамжуулах ремень	C4000Li 4063Ld	ш	8	2,445.6	19,565
2	Анхдагч /Б/бутлуурын хүч дамжуулах ремень	C4500Li 4558Ld	ш	8	2,853.1	22,825
3	Б булт бутлуурын хүч дамжуулах ремень	D8400Li	ш	20	7,132.9	142,659
4	А булт бутлуурын хүч дамжуулах ремень	D7500Li	ш	20	4,687.3	93,747
5	Үнсний бункерийн салхилуурын ремень	1882A	ш	12	244.5	2,935
6	Уутат шүүлтүүрийн салхилуурын ремень	1850A	ш	12	244.5	2,935
7	Банз /хар модон/	5см зузаантай 4м урттай	м3	2	9,171	18,342
8	Агаар шүүгч	PRIUS30 автомашины агаар шүүгчтэй адил	ш	12	305.6	3,668
9	Агаарын компрессорын дээд анги	W0.9/8	ком	1	16,304	16,304
10	Агаарын компрессорын дээд анги	W0.65/8	ком	1	15,285	15,285
11	Угаалгын шланг	D25мм-ийн диаметртэй механик үйлчлэлдд тэсвэртэй олсон үетэй хар резин шланг	м	100	163	16,304
12	Угаалгын шланг	D20мм-ийн диаметртэй механик үйлчлэлдд тэсвэртэй олсон үетэй хар резин шланг	м	100	163	16,304
13	Автогений шланг	D15мм-ийн диаметртэй механик үйлчлэлдд тэсвэртэй олсон үетэй хар резин шланг	м	30	163	4,891
14	Анхдагч бутлуурын алх А	5кг-ийн хатуулаг өндөртэй сайжруулсан ган ,	кг	12	4,483,5	53,803
15	Анхдагч бутлуурын алх Б	11,5кг-ийн хатуулаг өндөртэй сайжруулсан ган	кг	12	3,464,5	41,575
16	Трубо	Ф15	тн	0,5	1,630.5	3,261

17	Трубо	Ф25	тн	0,5	1,630.5	3,261
18	Лист	3-5мм	тн	0,5	11,209	22,418
19	Угольник	15-40	тн	0,5	3,566,5	7,133
20	Буцаах салхилуурын агаар шүүгч	RSR200H	ш	3	2,649.3	7,948
21	Үеийн элс нэмэх тэжээгчийн гинж	XDS250-00	ш	2	1,426.55	2,853
22	Үнсний бункерийн салхилуур агаар шүүгч	FRB100	ш	2	305.5	611
23	Усны тоолуур	LXLG-80 40м3/ц	ш	1	10,597	10,597
24	Усны тоолуур	LXS-50 15м3/ц	ш	1	8,763	8,763
25	Деараторын усны зарцуулалтын тоолуур	PN 16, DN150	ш	1	306	306
26	Катанг төмөр	6мм	кг	500	28,532	14,266
27	Төмөр утас	4мм /зөөлөн/	боодол	20	611.4	12,228
28	Барилгын шатны хомут	Эргэдэг /ширэм	ш	100	24,455	2,445,575
29	Барилгын шатны хомут	Эргэдэггүй/ ширэм/	ш	100	24,455	2,445,575
30	Шуудай	50кг	ш	2,000	10,189.8	20,379,793
31	Барилгын шатны хомут	холбогч /ширэм/	ш	100	24,455	2,445,575
32	Зөөлөн зузаан хар резинэн шланк	Ø20-25мм	м	100	97,823	9,782,301
33	Шугам хоолой	DN100 PN10,UPVC	м	27	203.8	5,503
34	Булан	DN100,PN10	ш	5	203.8	1,019
35	Фланц	DN100,PN10	ш	1	611	611
36	Шугам	(UPVC DN65,PN10)	м	4	611	2,446
37	Муфтэн холбоос	(UPVC DN65,PN10)	ш	1	102	102
38	UPVC шугам наах цавуу	Технологийн усын шугамд зориулагдсан.	хайрцаг	2	305	611
39	Шилэн хөвөн	5см зузаан,60см өргөн	боодол	3	815.3	2,446
40	Шилэн даавуу	1м өргөн	боодол	3	1,019	3,057
41	Тросс	Ø6 мм	м	350	61.1	21,399
42	Тросс	Ø8 мм	м	40	61.1	2,446
43	Шланк	Ø32 мм	м	30	163	4,891
44	Хаягдлын шланг	D50	м	100	203.8	20,380
45	Кондактор цэвэрлэгч	Хятад	ш	310	91.7	28,430
46	Компрессорын V ремень	1650-1720	ш	5	611	3,057
	Бүгд үнэ					38,160,000

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ТҮЛШ ДАМЖУУЛАХ
ЦЕХИЙН ДАРГА *de* Д.ТҮВШИНЗАЯА

“ШИЖИР ХИЙЦ” ХХК-ИЙН
ДИРЕКЦИЙН
ХҮК
ЗАХИРАЛ *MB* Б.БАТЭРДЭНЭ

